



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/537

Чойбалсан

Г Тусгай зөвшөөрөл олгох тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоох тухай” 2023 оны А/470, А327, А306 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн аж ахуйн нэгжийн цахимаар гаргасан хүсэлт, “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн 2025 оны 08 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн мэргэжлийн байгууллагын стандартын шалгуур үзүүлэлт, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангасан нэр бүхий 2 аж ахуйн нэгжүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгож, хавсралтаар баталсугай.

2. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг аж ахуйн нэгжийн захирал нарт, хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжүүдэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа П.Мөнхбаяр), аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Д.Мөнхбаяр), Чойбалсан сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн дэд дарга (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ЕЛ



My computer D/ Zakhiramj
2125011382

Аймгийн Засаг даргын 2025 оны
11 дүгээр сарын 06-ны өдрийн
А/337 дугаар захирамжийн хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ 1 ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР, 1 РЕСТОРАН

| № | Сумын нэр | Байршил, хаяг | Тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргасан ААНэгжийн нэр | Оноосон нэр | Үйлчилгээний төрөл, стандарт | Хугацаа |
|---|-----------|---|--|-------------|--------------------------------|--------------------------|
| 1 | Чойбалсан | 1 дүгээр баг, Хулстай гудамж 2-201 тоот | Хулстайн шимт ХХК | Шим маркет | Хүнсний дэлгүүр MNS5021-1:2024 | 2025.11.06 2030.11.06 |
| 2 | Чойбалсан | 2 дугаар баг, Цантын худаг 0-1 тоот | Хэрлэнгийн алтан бүргэд ХХК | Баатар хат | Ресторан MNS4946:2019 | 2025.11.06 2030.11.06 |

---oOo---

۱) سرتمیز لدر رنجرعبر قو رنجرعبر مسوعو بکلیسو در بکلیس مر لرسم صمغز (لدر بکلیس لر . بکلیس مر
ررسم مر صک صمغز) (۲-۳ ژسروبو) قو صتنتبشربننر ..

